ДАРХАН-УУЛ АЙМАГ, ШАРЫН ГОЛ СУМ




2026он

# " ШАРЫН ГОЛ СУМ ДАРХАН БАГИЙН"
# НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ

**Нийт төсөвт өртөг: 12,200,000 төгрөг**

## 1. Төслийн үндэслэл

- Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөнд нэгдэж, дэлхийн дулаарал, цөлжилтийн эсрэг сумын түвшинд бодит хувь нэмэр оруулах.
- Шарын гол сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.
- Шарын голын төв замын дагуу 14-р цэцэрлэгийн урд талбайд мод тарьж ногоон орчин бий болгосоноор иргэдийн эрүүл мэндэд зэрэгээр нөлөөлж амьдрах, амрах таатай орчин бүрдэнэ.
- Орчны тоосжилт бууруулах, цэвэр агаартай эрүүл орчныг бий болгох
- Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн эко боловсрол олгох ногоон төгөл цэцэрлэгт хүрээлэн бий болно.

## 2. Төслийн зорилго

Шарын гол сумын төв зам дагуу 14-р цэцэрлэгийн урд талбайд Шинэс,Гацуур болон навчит модны суулгац тарьж ногоон орчныг бүрдүүлж цэвэр эрүүл орчинг бий болгоно.Ногоон байгууламж нэмэгдүүлж мод тарьснаар хүүхэд залуус байгалиа хайрлан хамгаалах мод тарих зөв үлгэр жишээг үзүүлнэ.

## 3. Төслийн мэдээлэл

| | |
|---|---|
| Төслийн нэр | "НЭГ МОДНООС-НОГООН ИРЭЭДҮЙ" Дархан багийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төсөл |
| **Хэрэгжих байршил** | Дархан-Уул аймаг, Шарын гол сумын төв зам дагуу 14-р цэцэрлэгийн урд талбай |
| **Модны төрөл** | Бортоготой шинэс, Бортоготой гацуур, Монос, Өрөл |
| **НИЙТ ТӨСӨВ** | **12,200,000 төгрөг (Арван хоёр сая хоёр зуун мянга төгрөг)** |

## 4. Төслийн үйл ажиллагаа

| № | **Нэр төрөл үзүүлэлт** |
|---|---|
| 1 | Мод үржүүлгийн талбайгаас бортоготой модны суулгацнуудыг тээвэрлэн авчирч тарих. |
| 2 | **Модны төрөл**: Шинэс /бортоготой 1.5-1.7метр өндөр/, Гацуур /бортоготой 1.2-1.5метр өндөр/, Монос /бортоготой 80-1.0 метр өндөр/ Өрөл /бортоготой 0.7-0.9 метр өндөр/ |
| 3 | **Хийгдэх ажил** |
| | • Талбай цэвэрлэгээ.<br>• Мод тарих стандарт нүх ухаж бэлдэх<br>• Шимт хөрс бэлтгэх тарих газар зөөвөрлөж авчрах |

| | |
|---|---|
| | • Бэлэн бортоготой суулгацнуудыг технологийн дагуу зөв тарих<br>• Тарилтын өмнөх болон дараах усалгаа хийх / ачааны машинаар ус зөөвөрлөх/<br>• Тарилтын дараах арчилгаа хийх /хөрсөндөө дасан зохицох хугацаанд-3 жил / |

## 5. Төслийн төсөв

| № | Зардлын нэр | Тоо хэмжээ | Нэгж | Нэгж үнэ (₮) | Нийт дүн (₮) | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бортоготой шинэс | 20 | ш | 180,000 | 3,600,000 | 7-8 настай, 1.5-1.7 метр өндөр бортоготой стандарт шаардлага хангасан |
| 2 | Бортоготой гацуур | 20 | ш | 200,000 | 4,000,000 | 6-8 настай, 1.2-1.5 метр өндөр бортоготой стандарт шаардлага хангасан |
| 3 | Монос бортоготой | 10 | ш | 85,000 | 850,000 | 0.8-1.0 метр Стандарт шаардлага хангасан |
| 4 | Өрөл | 15 | ш | 55,000 | 825,000 | 0.7-0.9 метр Стандарт шаардлага хангасан |
| 5 | Мод тарих нүх ухах | 65 | нүх | 20,000 | 1,300,000 | Стандарт нүх ухах, тарьцыг зөв суулгаж тарих |
| 7 | Усалгааны машин | багц | - | 520,000 | 520,000 | Тарилтын өмнөх ба дараах усалгаа арчилгаа |
| 8 | Бордоо | багц | | 300,000 | 300,000 | Үндэсний систем идэвхжүүлэх, хөрсөндөө дасан зохицоход зориулсан. |
| 9 | Шимт хөрс бэлтгэх зөөх | багц | | 805,000 | 805,000 | Хар шороо ,бууц үртэс холимогоор шимт хөрс бэлтгэх |
| | | | | НИЙТ ДҮН: | 12,200,000 | Арван хоёр сая хоёр зуун мянган төгрөг |

**Нийт төсвийн дүн: 12,200,000 төгрөг**

## 6.Төслийн үр дүн

- Шарын гол сумын өнгө үзэмж нэмэгдэн тоосжилт буурч эрүүл ногоон цэцэрлэг бий болно.
- Иргэдийн байгаль хамгаалах, модоо хайрлан хамгаалах мэдлэг, хариуцлага нэмэгдэнэ.
- Хөрсний элэгдэл урт хугацаанд тодорхой хэмжээнд буурна.
- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд сумын хэмжээнд бодит хувь нэмэр оруулна.